# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

[+] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

[ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | 2019.06.27 |

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| Хамгаалалтын ажилтан | ТТ-7 |
| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын 8 цаг | Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар, нэгжийн байр |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | -хоригдолтой ажилласны нэмэгдэл<br>-онцгой нөхцөлийн нэмэгдэл<br>-цолны нэмэгдэл<br>-төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

Төрийн албаны тухай хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж хоригдол, хоригдогсдын зүгээс гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад оршино.

**Албан тушаалын зорилт:**
1.ШШГТ хууль болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллах.
2.Хоригдол, хоригдогсдын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох.
3.ШШГЕГ болон анги, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг цаг тухайд нь түргэн шуурхай биелүүлж, эргэн илтгэх.
4.Анги, байгууллагын хэмжээнд хийгдэж буй хоригдлын болон гаднаас нэвтэрч буй албан тушаалтан, иргэн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тогтоох.
5.Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т Хариуцан гүйцэтгэх –Г Хянах –Х Шийдвэрлэх - Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1."Хорих ангийн харуул хамгаалалтын журам"-д заасан ажил үүргийг хэрэгжүүлэн ажиллах<br>2.Харуул хамгаалалтын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, журам, заавар, стандартыг нэг бүрчлэн судалж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж орголт, гэмт хэрэг, зөрчил гаргуулахгүй байх<br>3.Харуул хамгаалалтад ашиглагдаж буй тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах<br>4.Анги, байгууллагын дотоод цагийн хуваарийн биелэлтийг хангуулах, хоригдлын дэглэм журмыг сахиулах<br>5.Хоногийн жижүүрийн хугацаанд хөтлөгдөх баримт бичиг, тусгай хэрэгсэл зэргийг биечлэн хариуцах | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана. | Г<br>Г<br>Г<br>Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Анги, байгууллагын харуул хамгаалалтын нөхцөл байдлыг удирдах албан тушаалтанд болон ерөнхий жижүүр, ээлжийн даргад тогтоосон хугацаанд илтгэх<br>2.Хоригдол, хоригдогсдын байр, бие, эд зүйлд хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг, нэгжлэгийг чанартай хийж, хураагдсан зүйл болон илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэж ажиллах.<br>3.Хоригдол, хоригдогсдын аюулгүй байдлыг хангах, тэдгээрийг гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх | Болзошгй эрсдлээс урьдчилан сэргийлж, таслан зогсооно | Г<br>Г<br>Г<br>Г |

| | | | |
|---|---|---|---|
| | 4.Хоригдол, хоригдогсдын хөдөлгөөнд /гадна эмнэлэг, хэсэг салбар, эргэлт, уулзалт/ биечлэн хяналт тавих.<br>5.Гэмт хэргийн шинжтэй мэдээллийг нэн даруй удирдах албан тушаалтанд танилцуулах.<br>6.Өөрийн хариуцсан обьект, хэсгийн онцлог, хяналт тавих нөхцөл, хоригдол, хоригдогсдын хөдөлгөөний чиглэл, хамгаалалтын тоног төхөөремж, эмзэг цэгийн талаар мэдэж байх.<br>7.Анги байгууллагын дэглэм, газарзүйн байршил, онцлог, үйлдвэрлэлийн чиглэл, үүрэг гүйцэтгэх обьектын нөхцөл байдалд тохируулан үүрэг гүйцэтгэх. | | Г<br>Г<br>Г<br>Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Удирдах дээд албан тушаалтнаас өгсөн үүрэг, даалгаврыг хугацаанд нь биелүүлж биелэлтийг эргэн илтгэх.<br>2.Анги, байгууллагын удирдлагуудыг шаардлагатай мэдээллээр хангах, үйл ажиллагааныхаа талаар танилцуулах. | Багаар ажиллах ажиллагааг нэмэгдүүлнэ | Г<br>Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Хорих анги, байгууллагын хамгаалалтын бүсэд зохих зөвшөөрлийн дагуу нэвтрүүлсэн иргэн, албан тушаалтан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тогтоох.<br>2.Анги, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах. | Байгууллагын болон алба хаагчийн аюулгүй байдал хангагдана | Х<br>Г |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1.ШШГБ-д дагаж мөрдөж буй хууль, дүрэм, журам, заавар, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу мөрдөж ажиллана<br>2.Төрийн болон албаны, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, хамгаалж ажиллах.<br>3.ШШГБ-ын "Мэдээллийн аюулгүй байдлын журам"-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж албаны шугамаар олж авсан мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах.<br>4.Тухайн онд хөтлөгдсөн баримт бичгийг стандартын дагуу үдэж, хавтаслан дараа оны 1 дүгээр улиралд багтаан архивт шилжүүлэх.<br>5.Удирдлагын шийдвэрээр болон цаг үеийн нөхцлөөс хамааран нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлж, уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэх. | Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | Г<br>Г<br>Г<br>Г<br>Г |

| III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | |
|---|---|
| **Боловсрол** | Бүрэн дунд |
| **Мэргэжил** | Шаардлага тавихгүй |
| **Мэргэшил** | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зохион байгуулсан мэргэжлийн сургалтад хамрагдсан байх |
| **Туршлага** | Цэргийн алба хаасан байх |
| **Ур чадвар** | -Багаар болон бие даан ажиллах чадвартай<br>-Шинийг санаачлах, бүтээлч сэтгэлгээтэй, идэвх санаачлагатай<br>-Баримт бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөлтийн чадвартай байх<br>-Үнэнч шударга, ажилдаа хариуцлагатай ханддаг, аливаад хянуур нягт нямбай, шуурхай ханддаг байх<br>-Монгол хэл бичгийн дүрмийн мэдлэг, чадвартай байх |

| IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ | |
|---|---|
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр<br>-Хорих анги, газар, хэлтэс, салбар нэгжийн дарга;<br>-Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга<br>-Ерөнхий жижүүр, ээлжийн дарга<br>-Гадна хамгаалалтын байцаагчид | |
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br><br>Нийт: Батлагдсан орон тоогоор | Бусад харилцах субъект:<br>1. Иргэн<br>2. Байгууллага |

| V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ | |
|---|---|
| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:** |
| Албан тушаал: Захиргааны удирдлагын газрын дарга, дэд хурандаа<br>С.Батбямба<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>TTC6684<br>2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр | Байгууллагын нэр: ХЗДХЯ<br><br>Шийдвэрийн огноо: 2019.06.25<br><br>Дугаар: 1-4/3037 |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** | |
| Байгууллагын нэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар<br><br>Шийдвэрийн огноо: 2019.06.27<br><br>Дугаар: А/126<br><br>(тамга/тэмдэг)<br><br>Дарга, хурандаа ........................................ Д.Дамдинцэрэн<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2019 оны 06 дугаар сарын 27-ны өдөр | |

--oOo--